



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 69

Даланзадгад сум

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 298 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хог хаягдлын 2021-2024 оны менежментийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д даалгасугай.

3. Энэхүү төлөвлөгөөг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан хэрэгжүүлж, үр дүнг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАДРАА

**АЙМГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ /2021 – 2024 он/**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

2017 оны 05 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ -ийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 298 дугаар тогтоолоор батлагдсан “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтуудыг үндэслэл болгов.

Өмнөговь аймаг нь 165 мянган км<sup>2</sup> газар нутагтай бөгөөд 15 сумын засаг захиргааны нэгж 71, 493 мянган хүн амтай аймаг юм. Хог хаягдлаас хүний эрүүл мэнд, цэвэр аюулгүй орчинд амьдрах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, байгалийн нөөц баялгийг хэмнэх, экологийн боловсролыг бага наснаас нь эзэмшүүлэх, хог хаягдлыг байгаль орчинд халгүй технологиор устгаж, булшлах зэрэг харилцааг зохицуулахад оршино.

**1.1. Өмнөговь аймгийн хог хаягдлын өнөөгийн байдал:**

Аймгийн хэмжээнд хог хаягдлын төвлөрсөн 25 цэг байгаа бөгөөд 88.14 га газрыг хамарч байна.

2020 оны байдлаар 220156.83 тонн энгийн хог хаягдал үүссэн байна. Үүнээс:

Цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал	тонн	1178.17
Шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал	тонн	1534.50
Хаягдал төмөр	тонн	5448.04
Хуванцар бүтээгдэхүүний хаягдал	тонн	2144.04
Барилгын хог хаягдал	тонн	10263.34
Хүнсний бүтээгдэхүүний хаягдал	тонн	4025.04
Цахилгаан барааны хаягдал	тонн	189.10
Автомашин эд анги	тонн	3581.20
Бусад хаягдал	тонн	191793.40
-Ландфилл булшилсан	тонн	210798.83
-Шатаасан	тонн	9350.00
<b>Нийт төвлөрсөн хог хаягдлын хураамжийн</b>	<b>Мян.төг</b>	<b>474941.40</b>

2020 оны байдлаар 2821.25 тонн аюултай хог хаягдал үүссэн байна. Үүнээс:

Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас	тонн	62.88
Боловсрол, шинжлэх ухааны байгууллагаас	тонн	2.07
Уул уурхайн үйл ажиллагаанаас	тонн	2711.80
Химийн бодисын үйлдвэрлэлээс	тонн	38.00
Ахуйн хэрэглээнээс	тонн	0.10

Арьс шир, үслэг, ноос ноолуур, ээрмэлийн үйлдвэрлэлээс	тонн	0.50
Бусад	тонн	5.90

Аюултай хог хаягдал устгасан байдал:

Ландфиллд булшилсан байдал	тонн	0.20
Зориулалтын байгууламжид шатаасан	тонн	61.10
Халдваргүйжүүлсэн	тонн	7.49
Саармагжуулж, савлаж хадгалсан	тонн	7.15
бусад	тонн	2745.31

## 1.2. Тулгамдаж буй асуудал:

Хог хаягдлын менежментийг сайжруулах талаар нэлээдгүй ажлууд хийгдэж байгаа ч уул уурхай дагасан хүн амын эрчимтэй өсөлттэй холбоотой хэрэглээ нэмэгдэж агаар хөрсний бохирдол, хог хаягдал нэмэгдсэнээр түүнд хүрч үйлчлэхэд хүндрэл бий болсоор байна.

Хог үүсэхээс эхлээд хогийн цэг хүртэлх үйл явцад олон асуудлууд шийдлээ хүлээж байна.

Үйл ажиллагаатай холбоотой:

- Ил задгай үүсмэл хог хаягдал үүсэх
- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах соёл нэвтрээгүй
- Гудамж талбайн цэвэрлэгээ хангалттай хэмжээнд хийгдэхгүй
- Орон сууц гэр хорооллын дундах нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ орхигдсон
- Томоохон худалдааны төвд түрээсээр лангуу түрээслэгчид болон супермаркетууд овор хэмжээ ихтэй хог хаягдлыг нийтийн эзэмшлийн хогийн цэгт хаядаг, үүнээс үүдэлтэй хогийн сав дүүрч гадуур нь хог хальж хотын өнгө үзэмжид нөлөөлдөг
- Иргэдийн ахуйн хог хаягдалд хандах ухамсар, соёлын түвшин доогуур
- Барилгын болон ахуйн хог хаягдлыг хууль бусаар хаяж орчныг бохирдуулдаг
- Ахуйн болон бохир шингэн хог хаягдлыг хог хаягдлын зориулалтын бус газар асгадаг

Техник технологийн шийдэлтэй холбоотой:

- Хог хаягдлыг тээвэрлэх автомашин хүрэлцээ муутай, БНХАУ-д үйлдвэрлэгдсэн зориулалтын автомашин нь 2 жил болоод хуучирч муудсан, засварлагдах боломжгүй болсон
- Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний ажилчид цөөн, хэрэглэгдэх багаж төхөөрөмж байхгүй,
- Хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах техник, технологи хөгжөөгүй
- Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагаа тогтолцоо байхгүй, тээвэрлэж ирсэн хогийг хэмжих пүү, хогийг түрж булах бульдозергүй

Оролцогч талуудын түвшинд

- Хог хаягдлын менежментэд оролцогч талуудын чиг үүргийг оновчтой болгох, хамтын ажиллагаа, уялдааг бэхжүүлэх
- Хог хаягдлын төлбөр, тооцоо, цуглуулалттай холбоотой санхүүгийн механизмыг боловсронгуй болгох

- Хяналт шалгалт, мониторингийн тогтолцоог боловсронгуй болгох
- Тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах

### Хоёр. Үндсэн зорилго, зорилт

Энэхүү төлөвлөгөөний үндсэн зорилго нь “Өмнөговь аймгийн иргэдийг эрүүл, аюулгүй, орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах хог хаягдлын менежментийн тогтолцоог бий болгох” юм.

Уг зорилтод хүрэхийн тулд “Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн тавдугаар бүлэг буюу “Ногоон хөгжлийн бодлого”, Өмнөговь аймгийг 2020-2024 онд хөгжүүлэх аймгийн засаг даргын үйл ажиллагааны “Нутгийн хишиг хөтөлбөр”-ийн тавдугаар бүлэг буюу “ГОВЬ-БАЙГАЛЬ ОРЧИН, ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ, УС, БЭЛЧЭЭРИЙГ ХАМГААЛАХ” зэрэг төр засгийн бодлого чиглэл бүхий баримт бичиг нь энэхүү төлөвлөгөөний үндэс суурь болов.

Төлөвлөгөөний зорилтыг ойлгомжтой, хэмжигдэхүйц, залгамж чанараа хадгалсан, үр дүнтэй нөхцөлийг харгалзан үзэж дараах байдлаар тодорхойлов.

1. Хог хаягдлын талаарх иргэд, олон нийтийн мэдлэг ухамсрыг дээшлүүлэх
2. Хог хаягдлыг анхан шатны эх үүсвэр дээр ангилан ялгаж, гарах хог хаягдлын хэмжээг багасгах ажиллагааг дэмжих
3. Хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх, ялгах, дахин боловсруулах ажлыг сайжруулж байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай хог хаягдлыг дарж булшлах
4. Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих
5. Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах
6. Төр засаг, хувийн хэвшил, олон нийтийн хамтын ажиллагааг бэхжүүлж хариуцлагын тогтолцоог сайжруулах
7. Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах

### Оролцогч талууд, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг тодорхойлох нь:

Оролцогч талууд	Гүйцэтгэх үүрэг
	Удирдах байгууллага
Аймгийн Засаг даргын Тамгын газар	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдлын хураамжийг судлан тогтоож батлуулах, мөрдүүлэх</li> <li>• Хог хаягдлыг эх үүсвэрээс устгах хүртэлх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн актуудыг боловсруулан, мөрдүүлэх</li> <li>• Аймгийн хэмжээнд хэрэгжих төсөл хөтөлбөрийг удирдан чиглүүлэх</li> <li>• Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр, устгах байгууламж байгуулах зөвшөөрөл олгох тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих</li> <li>• Хог хаягдлын хэмжээг бууруулах, хаягдалгүй ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллагад олгох мөнгөн урамшууллын журмыг батлуулж, мөрдөх</li> <li>• Аюултай хог хаягдлыг түр хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, өндөр даралтын автоклавтай болох,</li> </ul>

	<p>үйл ажиллагаанд хяналт тавьж байнгын бүртгэл хөтөлгөө хийлгэж хэвшүүлэх</p>
<p>Сумын Засаг даргын Тамгын газар</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдлын талаар гарсан эрхзүйн актуудыг хэрэгжүүлэх</li> <li>• Хог хаягдлыг ачиж цуглуулах нэгдсэн хуваарь, тээвэрлэх маршрутыг баталж, мөрдүүлэх, хяналт тавих</li> <li>• Байгууллага, аж ахуй нэгжүүд, айл өрхийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх хог тээвэрлэгч байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих, санхүүжүүлэх мета мэдээллийн сан үүсгэж байнгын хөтөлгөө хийж ажиллах</li> <li>• Хог гаргаж буй аж ахуйн нэгж, байгууллага нь үүсгэж буй хог хаягдлаа коджуулж бүртгэх</li> <li>• Сумын нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа, үйлчилгээг зохион байгуулж, шаардагдах санхүүжилтийг өөрийн төсөвт жил бүр тусгаж хяналт тавьж ажиллах</li> <li>• Хот тохижилтын ажилчдын хөдөлмөр хамгаалал, нийгмийн асуудлыг сайжруулах</li> <li>• Хог хаягдлын талаар багуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч олон нийтэд хог хаягдлын талаар сургалт, сурталчилгаа хийж ажиллах</li> <li>• Сумын хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах</li> <li>• Иргэдээс гарсан гомдол санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх</li> <li>• Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа бүх нийтийн их цэвэрлэгээний ажилд шаардагдах багаж хэрэгсэл, машин техник, хүн хүчийг бэлтгэж хангах</li> <li>• Нийтийн эзэмшлийн зам талбайг хогийн саваар хангаж, тоо хэмжээг нэмэгдүүлэх, хогийн савыг эзэнжүүлж, арчлуулах</li> <li>• Ил задгай хог хаягдалд хяналт тавих эргүүл ажиллуулж, холбогдох байгууллагуудтай хамтарч, ил задгай хог хаягдал үүсэхгүй байх арга хэмжээг авч ажиллах</li> <li>• Улсын болон орон нутгийн хөрөнгөөр худалдан авсан цэвэрлэгээ, үйлчилгээний тусгай зориулалтын болон хог тээврийн автомашины ашиглалт, үйлчилгээнд хяналт тавьж ажиллах</li> <li>• Зам талбайн үйлчлэгчдийн багаж хэрэгслийг сайжруулах, боловсронгуй болгох, хангамжийг сайжруулах арга хэмжээг авах</li> </ul>
<p>Баг</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдал цуглуулж, тээвэрлэх хуваарь гаргаж мөрдүүлэх хяналт тавих</li> <li>• Хог хаягдал цуглуулж тээвэрлэх гэрээг цуцлах саналыг сумын Засаг даргад хүргүүлэх</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Айл өрх байгууллага аж ахуй нэгжүүдийн хог хаягдлаа ангилан ялгаж хаяж байгаа байдалд хяналт тавьж ажиллах</li> <li>• Бүх нийтийн цэвэрлэгээний ажилд иргэд, аж ахуйн нэгжийн татан оролцуулж хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулна.</li> </ul>
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдлын талаар гарсан эрхзүйн актуудыг хэрэгжүүлэх</li> <li>• Хог хаягдлын талаар сум, багуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч олон нийтэд хог хаягдлын талаар сургалт, сурталчилгаа хийж ажиллах</li> <li>•</li> </ul>
<b>Хяналт тавих байгууллага</b>	
Мэргэжлийн хяналтын газар	<ul style="list-style-type: none"> <li>• Хог цэвэрлэгээний биелэлтэд хяналт тавьж, дүгнэлт гаргаж хариуцсан байгууллагуудад дүгнэлт хүргүүлж ажиллах</li> <li>• Хууль журмыг зөрчсөн иргэн, байгууллага, аж ахуй нэгжид хуулийн хариуцлага тооцох</li> </ul>
<b>Гүйцэтгэгч байгууллага</b>	
Сумын Захирагчийн ажлын алба	<ul style="list-style-type: none"> <li>• Батлагдсан төлөвлөгөө, маршрут, графикийн дагуу төсөвлөгдсөн хөрөнгөнд багтаан хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийг хийх</li> <li>• Хог хаягдлыг хогийн төвлөрсөн цэгт дарж, устгах ажлыг байгальд халгүй технологиор хийж гүйцэтгэх</li> <li>• Золбин нохой муурыг устгах</li> <li>• Төвлөрсөн цэг дээр байгуулагдсан хогийн ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг хөтлөн явуулах, камержуулах</li> </ul>
Хог тээвэрлэгч, устгах үйл ажиллагааг эрхлэгч байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>• Сум багтай хамтран хог цуглуулж тээвэрлэх хуваарь гарган хуваарийн дагуу ажиллах</li> <li>• Хогоо заавар журмын дагуу хадгалаагүй, уут саванд хийгээгүй, хуваарийн дагуу хогоо ачуулаагүй байгууллага, аж ахуй нэгжүүдийн талаар холбогдох төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх</li> </ul>
Сууц өмчлөгчдийн холбоо	<ul style="list-style-type: none"> <li>• Сум багтай хамтран хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг зохион байгуулах</li> <li>• СӨХ-ийн эзэмшил талбайн хог, цас мөсийг цэвэрлэх</li> <li>• Хог ачиж, цуглуулах, хуваарь, хог хаягдлыг зүй зохистой хадгалах, ачуулах заавар журмын дагуу хог хаягдлыг хадгалж, ачуулах</li> </ul>
<b>Үйлчлүүлэгч ба хэрэглэгч</b>	
Байгууллага, аж ахуй нэгж	<ul style="list-style-type: none"> <li>• Байгууллага, аж ахуй нэгжүүд хог хаягдлын үйлчилгээний хураамжийг харьяалах сумын төсөвт төвлөрүүлж, сумтай гэрээ байгуулсан хог тээвэрлэгч байгууллагаар үйлчлүүлнэ.</li> <li>• Хог хаягдлаа заавар журмын дагуу ангилан ялгаж, ил задгай хог хаялгүйгээр хог тээврийн автомашинд хогоо хуваарийн дагуу ачуулна.</li> <li>• Хог хаягдлын талаар гарсан хууль, тогтоомж, шийдвэрийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.</li> </ul>



	<ul style="list-style-type: none"> <li>• Хог хаягдлаа заавар журмын дагуу уутанд хийж уутыг битүүмжлэн автомашин болон төвлөрүүлэн ачдаг цэгт салхинд хийсэж ил задгай тархахгүй байхаар зориулалтын битүү саванд хог хаягдлыг байршуулсан байна.</li> <li>• Төр захиргааны байгууллагаас гарсан шийдвэрийн дагуу хийгдэж байгаа бүх нийтийн цэвэрлэгээний ажилд идэвхтэй оролцоно.</li> <li>• Нийтийн эзэмшлийн зам талбай болон өөрийн байгууллагын орчинд ил задгай хог хаягдал хаясан иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид хяналт тавьж холбогдох төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж ажиллана.</li> </ul>
Иргэн ба айл өрх	<ul style="list-style-type: none"> <li>• Гэр хорооллын айл өрх хог хаягдлаа заавар журмын дагуу савлаж түр хадгалах хог хаягдлыг тээвэрлэх батлагдсан хуваарьтай өдөр хог тээврийн машин ирэхэд хогоо хашааны үүдэнд гаргаж ачуулахад бэлтгэж өгнө.</li> <li>• Нийтийн орон сууцны айл өрхүүд хог хаягдлаа заавар журмын дагуу савлаж хог хаягдлыг тээвэрлэх батлагдсан хуваарьтай өдөр хог тээврийн дуут дохио бүхий машин ирэхэд хогоо гаргаж ачуулна.</li> <li>• Нийтийн эзэмшлийн зам, талбайд ил задгай хог хаяхгүй байх</li> <li>• Нийтийн эзэмшлийн зам талбай болон өөрийн байгууллагын орчинд ил задгай хог хаягдал хаясан иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид хяналт тавьж холбогдох төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж ажиллана.</li> </ul>

### Гурав. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа

Төлөвлөсөн зорилтод хүрэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах бөгөөд төлөвлөгөөг 2021-2024 он хүртэл хэрэгжүүлнэ.

### Дөрөв. Удирдлага зохион байгуулалт

- Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг АЗДТГ удирдан зохион байгуулна.
- Төлөвлөгөөг хэрэгжилтийг орон нутагт хэрэгжүүлж ажиллах, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр аймгийн ЗДТГ, ИТХ-д тайлагнах ажлыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сумын засаг дарга нар зохион байгуулна.

### Тав. Төлөвлөгөөний санхүүжилт

- 5.1. Улсын төсөв
- 5.2. Орон нутгийн төсөв
- 5.3. Байгаль хамгаалах сан
- 5.4. Уул уурхайн компаниудын хандив, тусламж
- 5.5. Олон улс болон гадаад дотоодын байгууллагын тусламж хандивын хөрөнгө
- 5.6. Иргэд хувийн хэвшлийн дэмжлэг
- 5.7. Бусад

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийг 2021 оны 05 дугаар сарын 05-ны  
өдрийн 69 дүгээр тогтоолын хавсралт

**АЙМГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа /оноор/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хөрөнгийн эх үүсвэр	Хамтран ажиллах байгууллага
<b>Зорилт 1. Хог хаягдлын талаарх иргэд, олон нийтийн мэдлэг ухамсрыг дээшлүүлэх</b>							
1.1	Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх болон хог ангилан ялгах талаар нийтийг хамарсан сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх	2021-2024	Нөлөөллийн ажилд хамрагдсан иргэдийн тоо	2100	3000	Орон нутгийн төсөв	БОАЖГ, Мэргэжлийн хяналтын газар, ГГБЦГХЗахиргаа, Боловсролын газар, Сумдын ЗДТГазар, Төрийн бус байгууллага
1.2	Хог хаягдлын талаар батлагдсан хууль, журам, эрхзүйн баримт бичгийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар сурталчлах	2021-2024	Арга хэмжээний тоо	5	10	Орон нутгийн төсөв	АЗДТГ, БОАЖГазар, Сумдын ЗДТГ, Мэргэжлийн хяналтын газар, ГГБЦГХЗахиргаа
1.3	Хог хаягдлын талаар иргэдийн дунд зөв дадал зуршил, ухамсар сэтгэлгээг төлөвшүүлэх ажлыг тусгай хөтөлбөрийн дагуу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр системтэй зохион байгуулах	2021-2024	Олон нийтэд хүргэсэн видео шторк нэвтрүүлгийн тоо	2	8	Орон нутгийн төсөв	АЗДТГ, БОАЖГазар, Мэргэжлийн хяналтын газар, ОНХА, Орон нутгийн телевизор
1.4	Аймгийн сургуулийн насны хүүхдүүдэд Насан туршийн боловсролын төвөөр дамжуулан хог хаягдлыг ангилан ялгах, хогоо хогийн саванд хийх талаар сургалт мэдээлэл өгөх	2021-2024	Сургалтад хамрагдсан хүүхдийн тоо	300	1000	Орон нутгийн төсөв	АЗДТГ, БОАЖГазар, Мэргэжлийн хяналтын газар, Сумдын ЗДТГ, Насан туршийн боловсролын төв



Зорилт 2. Хог хаягдлыг анхан шатны эх үүсвэр дээр ангилан ялгаж, гарах хог хаягдлын хэмжээг багасгах ажиллагааг дэмжих									
2.1	Сумдын гэр хороолол болон орон сууцыг хамарсан дахин ашиглах хаягдал болон хоёрдогч түүхий эдийг иргэдээс худалдан авах цэгийг байгуулж ажиллуулна.	2022	Түүхий эд худалдан авах цэгийн тоо	0	3	Орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр	АЗДТГ, БОАЖГазар, Сумдын ЗДТГ		
2.2	Сумдын айл өрхийг хог ангилан ялгах зориулалттай хогийн савтай болгох	2022-2024	Ангилан ялгах савтай болсон өрхийн тоо	100	400	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Сумдын ЗДТГ		
2.3	Аж ахуй нэгж, албан байгууллага, нийтийн эзэмшлийн талбайд шаардлага хангасан, ангилан ялгах хогийн сав байрлуулах ажлыг зохион байгуулна.	2021-2024	Нийтийн эзэмшлийн зам талбайд байрлуулсан хогийн савны тоо	20	30	Орон нутгийн төсөв	АЗДТГ, БОАЖГазар, Сумдын ЗДТГ		
2.4	Улсын болон орон нутгийн чанартай автозамын дагуу хог хаягдал ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав байрлуулах	2022	Хогийн савны тоо	0	2	Орон нутгийн төсөв	АЗДТГ, БОАЖГазар, Сумдын ЗДТГ		
Зорилт 3. Хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх, ялгах, дахин боловсруулах ажлыг сайжруулж байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай хог хаягдлыг дарж булшлах									
3.1	Сумдын хог хаягдлын автомашин, техник тоног төхөөрөмжийг үе шаттайгаар сайжруулж шинэчлэх	2022-2024	Автомашин тоо	36	40	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	АЗДТГ, БОАЖГ, Сумдын ЗДТГ		
3.2	Даланзадгад сумын Захирагчийн ажлын албыг хог түрж булах бульдозертэй болгох	2022	Техник хэрэгслийн тоо	0	1	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	АЗДТГ, БОАЖГ,		
3.3	3 дугаар зэрэглэлийн шаардлага хангасан хог хаягдлын цэг	2022	Батлагдсан зураг төсвийн тоо	0	1	Орон нутгийн төсөв	АЗДТГ, БОАЖГ,		

	байгуулах зураг төсөв боловсруулах								
3.4	Гурвантэс, Цогтцэций ландфилийн цэгийг байгуулж мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжээр тээвэрлэх, ангилан ялгах, булшлах, ажлыг гүйцэтгүүлнэ.	2022-2024	Байгуулсан ландфилийн тоо	1	3	Орон нутгийн төсөв, Уул уурхайн хандив тусламж	АЗДТГ, БОАЖГазар, Мэргэжлийн хяналтын газар, Сумдын ЗДТГ		
3.5	Сумдын хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулах, байнгын харуул хамгаалалт, хашаажуулах ажлыг зохион байгуулах	2022-2024	Тохижуулсан хогийн цэгийн тоо	0	3	Орон нутгийн төсөв	БОАЖГ, Сумдын ЗДТГ		
3.6	Улсын болон орон нутгийн чанартай авто зам, замын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих	2021-2024	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	8	Орон нутгийн төсөв	БОАЖГазар, Мэргэжлийн хяналтын газар, Сумдын ЗДТГ		
3.7	Сумдын хог хаягдлын цэгийг автопүүтэй болгох	2022-2024	Автопүүтэй болсон сумдын тоо	0	3	Орон нутгийн төсөв	АЗДТГ, БОАЖГазар, Сумдын ЗДТГ		
<b>Зорилт 4. Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих</b>									
4.1	Хог хаягдлыг боловсруулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжсэн, техник технологийн шийдэл бүхий төслүүдийг сонгон шалгаруулж, дэмжиж ажиллана.	2021-2024	Дэмжсэн төслийн тоо	0	1	Орон нутгийн төсөв	АЗДТГ, БОАЖГ, Сумдын ЗДТГ		
4.2	Хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах үйлдвэрийг шат дараалалтай байгуулж ашиглалтад оруулна. /хуванцар, шил, цахилгаан бараа/	2022-2024	Үйлдвэрийн тоо	0	1	Орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр	АЗДТГ, БОАЖГ, Даланзадгад сумын ЗДТГ, Захирагчийн ажлын алба		
4.3	Бараа бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг үйлдвэрлэгч	2021-2024	Дахин ашигласан	0	1	Орон нутгийн төсөв	БОАЖГ, Хувийн хэвшил		

	эргүүлэн татаж ашиглах, дахин боловсруулах нэвтрүүлэх			сав баглаа боодлын тоо					
4.4	Хаягдал дугуй бутлах төхөөрөмжийг ашиглалтад оруулах	2021	0	Буталсан хаягдал дугуйн тоо	3000	-		АЗДТГ, БОАЖГ	
<b>Зорилт 5. Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах</b>									
5.1	Зам талбай цэвэрлэх бага оврын тоног төхөөрөмжтэй болох	2022-2024	2	Тоног төхөөрөмжийн тоо	5	Орон нутгийн төсөв		АЗДТГ, БОАЖГ	
5.2	Зам талбайн үйлчлэгчдийг ажлын ачаалал, хот байгуулалттай уялдуулан тоо хэмжээг тогтооно.	2021	26	Шинээр нэмэгдсэн үйлчлэгчийн тоо	35	Орон нутгийн төсөв		Сумдын ЗДТГ, Захирагчийн ажлын алба	
5.3	Аймгийн хэмжээнд улирал болгоны сүүлийн долоо хоногийн хагас сайн өдөр бүх нийтийн хог цэвэрлэгээний өдөр болгон зарлах	2021	0	Баримт бичгийн тоо	1	-		АЗДТГазар, БОАЖГазар, Сумдын ЗДТГ	
5.4	Нийтийг хамарсан баяр, ёслол, наадам болон бүх төрлийн үйл ажиллагааны үеэр хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.	2021-2024	Жилд 2 удаа зохион байгуул аргатай хэмжээний тоо	байгуулагдсан арга хэмжээний тоо	8	Орон нутгийн төсөв		БОАЖГазар, Сумдын Засаг дарга	
<b>Зорилт 6. Төр засаг, хувийн хэвшил, олон нийтийн хамтын ажиллагааг бэхжүүлж хариуцлагын тогтолцоог сайжруулах</b>									
6.1	Шинээр баригдаж байгаа нийтийн орон сууцнуудыг хогийн бункертай хүлээж авах ажлыг эхлүүлэх, тогтмолжуулна	2021-2024	0	Хогийн савны тоо	4	-		АЗДТГ, ГХБХБГ, Сумдын ЗДТГ	
6.2	Аймгийн хэмжээнд нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох	2021	0	Баримт бичгийн тоо	1	-		АЗДТГ	

6.3	Энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг батлах	2021	Батлагдсан тогтоолын тоо	0	15	-	Сумдын ИТХ
6.4	Энгийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжийг бүртгэх	2021-2024	Бүртгэлийн дугаар авсан ААНэгжийн тоо	14	27	-	БОАЖГ
6.5	Нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох	2021	Батлагдсан тогтоолын тоо	0	15	-	Сумдын ИТХ, ЗДТГ
6.6	Даланзадгад сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулна	2021	Батлагдсан төлөвлөгөөний тоо	0	1	-	Даланзадгад сумын ЗДТГ, Захирагчийн ажлын алба
6.7	Аймгийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттай бууруулах арга хэмжээг авах шаардагдах зардлыг шийдвэрлэх	2021-2024	Эко жорлонтой болсон айл өрхийн тоо	0	800	Орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр	АЗДТГ, Холбогдох байгууллагууд
<b>Зорилт 7. Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах</b>							
7.1	Аюултай хог хаягдал үүсгэгч аж ахуй нэгжийг бүртгэх	2021-2024	Бүртгэлийн дугаар авсан ААНэгжийн тоо	14	50	-	БОАЖГ
7.2	Ерөнхий боловсролын сургуульд лабораторийн зорилгоор ашиглагдаж байсан нэр, төрөл нь тодорхойгүй химийн бодисын судалгааг хийж саармагжуулах, устгах ажлыг зохион байгуулах	2022	Хийгдсэн судалгааны тоо	0	1	Орон нутгийн төсөв	Мэргэжлийн хяналтын газар, Боловсрол соёл урлагын газар, мэргэжлийн байгууллага
			Судалгааны дагуу устгасан бодисын хувь	0	100%		

7.3	Аюултай хог хаягдал түр хадгалах цэгийг байгуулах	2022	Барилга байгууламжийн тоо	0	1	Улсын төсөв, Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	АЗДТГ, БОАЖГ
7.4	Сумдын эрүүл мэндийн төвийг ариутгах төхөөрөмжөөр хангах	2022-2023	Ариутгах тоног төхөөрөмжийн тоо	8	15	Орон нутгийн төсөв	АЗДТГ, ЭМГ
7.5	Төр хувийн хэвшлийн оролцоотой аюултай хог хаягдал устгах, дахин боловсруулах үйлдвэр байгуулах	2023	Үйлдвэрийн тоо	0	1	Орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр, Уул уурхайн хандив тусламж	АЗДТГ, БОАЖГ, МХГ